



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар Б/11

Бор-Өндөр сум

Соёлын төвийн дарга М.Чулуунцэцэгт
ур чадварын урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Соёлын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63, А/73 “Шалгуур үзүүлэлт батлах тухай” хамтарсан тушаалын хавсралтын 5.1, 6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын төвийн дарга М.Чулуунцэцэгийн ур чадварын үнэлгээ 91 хувьтай дүгнэгдсэн тул нэг удаа үндсэн цалингийн 25%, ур чадварын урамшууллыг сар бүр тооцож олгосугай.
2. Урамшууллыг цалингийн сангаас холбогдох журмын дагуу тооцож олгохыг Соёлын төвийн Нягтлан бодогч (М.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ